



# ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
доорх хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Хаяг:  
Сүмбэр сум, 3 дугаар баг, Нутгийн  
удирдлагын ордон 2 дугаар давхар

## Аудитын тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт .....3

### Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....4

Аудитын зорилт, хамарсан хүрээ.....4

Аудитын арга зүй.....4

ТТЗ-ийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд  
баримталсан бодлого, аргачлал.....4

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт .....5

Гурав. Шилэн дансны мэдээлэл.....6

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох.....6

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.....6

### Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар .....7

6.2. Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах  
дансны талаар .....7

6.3 Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн  
тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт,  
бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар.....8

### Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1. Авлагын бүтцийн талаар.....8

7.2. Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн  
тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай  
холбоотой гарсан зөрчлийн талаар.....9

### Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар .....9

### Ес. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар.....11

9.2 Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн  
тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл  
тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар .....12

<b>Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын талаар</b>	
10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар .....	12
10.2. Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар .....	13
<b>Арван нэг. Орлогын бүртгэл тайлагнал .....</b>	<b>14</b>
11.1 Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар .....	14
11.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар.....	14
11.3 Бусад эх үүсвэрийн талаар.....	15
<b>Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал.....</b>	<b>18</b>
12.1 Зардлын бүтцийн талаар .....	186
12.2 Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл,тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар.....	19
<b>Арван гурав. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой         гарсан зөрчлүүдийн талаар .....</b>	<b>19</b>
<b>Арван дөрөв: Хуримтлагдсан үр дүнгийн талаар.....</b>	<b>20</b>
<b>Арван тав: Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн         санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн         зөрчлийн нэгтгэл .....</b>	<b>20</b>
<b>Арван зургаа: Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....</b>	<b>20</b>
<b>Арван долоо. Шивээговь сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн         нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт.....</b>	<b>20</b>

## Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
СЯ	Сангийн яам
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн ОУС
ОН	Орон нутаг
ХО	Хөрөнгө оруулалт
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОННСТ	Орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан
СНТ	Нэгтгэсэн санхүүгийн тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТББ	Төрийн бус байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
МХС	Мал хамгаалах сан
БХС	Байгаль хамгаалах сан
ЖМС	Жижиг мөнгөн сан

## Нэг. Ерөнхий зүйл

### Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд /ГСА-2018/02-СТА-ТТЗ/ аудит хийлээ.

### Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг бүрэн ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт болно.

Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай шилжүүлгийн байгууллагууд, төсөл сангуудын нийт 10 тайланг хамруулан нэгтгэсэн тайланг аудитласан болно. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 2
- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 4
- Төсөл, сангуудын санхүүгийн тайлан 4

### Аудитын арга зүй

Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

## “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг баримтлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
<b>ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан</b>	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	Үндсэн хөрөнгө, бараа материал, өр, авлагын тодруулга тайлан байгууллагын төрлөөр
<b>ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан</b>	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	
<b>ОН-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан</b>	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
<b>ОН-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан</b>	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудаас Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ын дагуу “Э-тайлан” програмаар бэлтгэн гаргажээ.

Харин байгууллагын төрлөөрх тайланд сумдын сангийн дансдыг төсөвт байгууллагын хэсэгт нэгтгэн тайлагнасан бөгөөд энэ нь уг сангуудад төсөв батлагдаж байгаа гэсэн шалтгаанаар Сангийн яамнаас дээрх тохиргоо хийгдсэн байна.

### Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба”-наас Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгт төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтаар 16,375.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Шивээговь сумын Санхүүгийн албанаас нэгтгэсэн санхүүгийн тайлангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй

байхад анхаарч ажиллахын зэрэгцээ тус сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

### **Гурав. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тус сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн болон төсөл сангийн нийт 10 байгууллагыг хамруулан Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан дахь бие даасан цэсийг шалгахад нийт 1,477 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 20 мэдээлэл байгаа бөгөөд түүвэрт хамрагдсан төсөвт байгууллага, төсөл сангийн 4 цэсэнд нийт оруулсан мэдээллийн 0.5% буюу 7 мэдээлэл дутуу, 16.3% буюу 237 мэдээллийн хугацааг хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### **Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонголоо.

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,695,584.2 мянган төгрөгийн 1.5% буюу 40,433.8 мянган төгрөгөөр тооцов..

### **Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд орон нутгийн төсөвт байгууллага 2, тусгай шилжүүлгийн байгууллага 4, төрийн сан, төсөл, сангуудын 4 нийт 10 байгууллагын тайланг хамрууллаа.

Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг ирүүлэхээр заасан боловч 2018 оны 03 дугаар сарын 13-ны 2/181 дугаартай албан бичгээр хуулийн хугацааг 8 хоногоор хоцроож тайлангаа ирүүлсэн байна.

## Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

### 6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, төсөл сангийн үлдэгдэл
- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын нярвын данс, харилцах дансдын үлдэгдэл

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эцэст 31,195.3 мянган төгрөг байсан ба тайлант оны эцэст 54,209.0 мянган төгрөг болж 73.8% буюу 23,013.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байна.

Орон нутгийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө					
Төгрөг/ЖМС					
Касс					
Банкинд байгаа бэлэн мөнгө	31,195.34	54,209.06	-	-	54,209.06
Төгрөг	31,195.34	54,209.06		-	54,209.06
Гадаад валют					
Замд яваа мөнгөн хөрөнгө					
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>31,195.34</b>	<b>54,209.06</b>			<b>54,209.06</b>
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	17,047.00	16,224.93			
Төсөвт байгууллагууд	7,465.84	31,301.62			
ОНӨҮГ		-			
Төсөл, сангууд	6,682.50	6,682.50			

Хүснэгтээс харахад: Төсөвт байгууллагуудын тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь өмнөх оноос 23,835.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, төрийн сан дахь дансдын үлдэгдэл 822.0 мянган төгрөгөөр буурсан байна.

### 6.2 Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар

Төсвийн тухай хуулийн дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад тус сумын орон нутгийн орлогын дансууд үлдэгдэлгүй байна.



### **6.3. “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, зарцуулалттай холбоотой нийт **678,550.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад алдаа, зөрчлийг бүрэн залруулж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх тухай зөвлөмж өгөв.

Дээрх зөрчил дутагдал нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Нэгтгэлд хамрагдсан байгууллагуудад орон нутгийн төсвийн санхүүжилтийг улсын төсвийн санхүүжилтээр бүртгэж тайлагнасан нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа зөрчлүүд гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

## **Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал**

### **7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд авлагын эхний үлдэгдэл 175,513.4 мянган төгрөг байсан бол тайлант онд 1.3% буюу 2,270.7 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 173,242.6 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(мянган төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	30,93		- 30,93	-100,00
Байгууллагаас авах авлага	653,49	475,26	- 178,23	- 27,27
Хувь хүмүүсээс авах авлага	174 828,95	172 767,38	-2 061,57	- 1,18
<b>НИЙТ ДҮН</b>	<b>175 513,37</b>	<b>173 242,64</b>	<b>-2 270,73</b>	<b>-128,45</b>

Хүснэгтээс харахад: Нийт авлагын 0.3%-ийг байгууллагаас авах авлага, 99.7%-ийг хувь хүмүүсээс авах авлага эзлэж байна.

Хувь хүмүүсээс авах авлагын эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 1.1% буюу 2,061.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад авлага 27.2-100.0%-иар буурсан байна.

Авлагыг байгууллагын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулбал:

(мянган төгрөгөөр)						
Д/д	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
1	3-р сургууль	392.40	392.40	-	-	0.23
2	3-р цэцэрлэг	35.89		- 35.89	- 100.00	-
3	Мал хамгаалах сан		2,541.00	2,541.00	100.00	1.47
4	Соёлын төв	30.93		- 30.93	- 100.00	-
5	Сум хөгжүүлэх сан	173,960.85	170,226.38	- 3,734.47	- 2.15	98.26
6	Сумын ИТХ		49.76	49.76	100.00	0.03
7	Сумын ЗДТГ	225.20		- 225.20	- 100.00	-
8	Эрүүл мэндийн төв	868.10	33.10	- 835.00	- 96.19	0.02
<b>НИЙТ ДҮН</b>		<b>175,513.37</b>	<b>173,242.64</b>	<b>-2270.73</b>	<b>- 1.29</b>	<b>100.00</b>

Хүснэгтээс харахад: Тус сумын ЗДТГ, 3 дугаар цэцэрлэг, Соёлын төв авлагыг тус тус 100% барагдуулсан бол ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Сум хөгжүүлэх сангийн авлага 2.1-96.2%-иар буюу 225.2-3,734.5 мянган төгрөгөөр буурч, Шивээговь сумын ИТХ, Мал хамгаалах сангийн авлага нийт 2,590.85 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөн нийт 170,618.8 мянган төгрөгийн авлага нь 91-ээс дээш хоногийн насжилттай байгаа бөгөөд нийт авлагын 1.47%-ийг Мал хамгаалах сан, 98.26%-ийг Сум хөгжүүлэх сан, 0.2%-ийг 3 дугаар сургууль, 0.3%-ийг Шивээговь сумын ИТХ-ын авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардал дансны эхний үлдэгдэл 5,747.3 мянган төгрөг байсан бол тайлант онд 152.6% буюу 8,770.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 14,517.4 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүний 96.2% нь 3 дугаар сургууль, 3.8% нь 3 дугаар цэцэрлэгийн ахмадын санд шилжүүлсэн цалингийн хэмнэлт байна.

## **7.2 “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар авлагатай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

### **Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал**

#### **8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл 112,778.5 мянган төгрөг

Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

байсан бол эцсийн үлдэгдэл 135,191.8 мянган төгрөг болж тайлант онд бараа материалын үлдэгдэл 20.0%-иар буюу 22,413.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

(мянган төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	1,166.03	1,166.03	-	-
Эм боох материал	4,447.18	5,123.46	676.28	0.15
Бичиг хэргийн материал	4,086.78	4,591.28	504.50	0.12
Аж ахуйн материал	65,584.71	72,826.26	7,241.55	0.11
Сэлбэг хэрэгсэл	522.90	519.90	(3.00)	- 0.01
Түлш шатахуун, тослох материал	1,060.05	10.00	(1,050.05)	- 0.99
Барилга засварын материал	11.50	11.50	-	-
Хүнсний материал	9,219.70	16,444.50	7,224.80	0.78
Бусад хангамжийн материал	7,799.41	10,548.65	2,749.24	0.35
Мал амьтад	18,000.00	18,000.00	-	-
Нөөцийн бараа	880.30	5,950.30	5,070.00	5.76
<b>НИЙТ ДҮН</b>	<b>112,778.56</b>	<b>135,191.88</b>	<b>22,413.32</b>	<b>0.20</b>

Хүснэгтээс харахад: Эм боох материал 676.3 мянга, бичиг хэргийн материал 504.5 мянга, аж ахуйн материал 7,241.6 мянга, хүнсний материал 7,224.8 мянга, бусад хангамжийн материал 2,749.2 мянга, нөөцийн бараа материал 5,070.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад бараа материал 3.0-1,050.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 266,478.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба худалдаж авсан 253,665.2 мянга, үнэ төлбөргүй буюу хандив тусламжаар 12,812.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 244,064.8 мянган төгрөгөөр хасагдсан ба зарцуулсан 239,875.9 мянга, акталсан 4,188.9 мянга байна.

Бараа материалын үлдэгдлийн судалгааг байгууллагын төрлөөр нь хүснэгтээр үзүүлбэл:

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэлд эзлэх хувь
1	3-р сургууль	31,589.3	43,774.5	0.32
2	3-р цэцэрлэг	26,708.2	34,200.3	0.25
3	Мал хамгаалах сан	880.3	5,950.3	0.04
4	Соёлын төв	3,204.9	3,204.9	0.02
5	Сумын ЗДТГ	39,763.7	35,356.3	0.26
6	Сумын ИТХурал	1,309.0	1,280.5	0.01
7	Хүн эмнэлэг	9,323.2	11,425.1	0.08
	<b>Нийт дүн</b>	<b>112,778.6</b>	<b>135,191.9</b>	<b>1.00</b>

Хүснэгтээс харахад: Нийт бараа материалын үлдэгдлийн 27.0% буюу 36,636.8 мянган төгрөг нь орон нутгийн төсөвт байгууллагууд, 69.0% буюу 92,604.8 мянган төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд, 4.0% буюу 5,950.3 мянган төгрөгийн нөөцийн бараа мал хамгаалах сангийн дансанд тус тус бүртгэлтэй байна.

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

## Ес. Үндсэн хөрөнгийн талаар

### 9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө оны эхэнд 3,159,652.4 мянган төгрөг байсан бол тайлант онд 35.1% буюу 1,111,253.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 4,270,605.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь
1	Барилга байгууламж	2,408,136.93	3,539,408.54	1,131,271.61	0.83
2	Тээврийн хэрэгсэл	118,890.90	112,609.17	(6,281.73)	0.03
3	Машин тоног төхөөрөмж	108,230.88	94,021.37	(14,209.51)	0.02
4	Тавилга эд хогшил	63,047.95	45,664.90	(17,383.06)	0.01
5	Номын фонд	26,828.29	30,631.91	3,803.62	0.01
6	Биет бус хөрөнгө	1,447.17	981.46	(465.71)	0.00
7	Бусад үндсэн хөрөнгө	432,770.32	447,288.61	14,518.28	0.10
	<b>Дүн</b>	<b>3,159,352.44</b>	<b>4,270,605.95</b>	<b>1,111,253.51</b>	<b>1.00</b>

Хүснэгтээс харахад: Нийт үндсэн хөрөнгийн 82.9%-ийг барилга байгууламж, 2.6%-ийг тээврийн хэрэгсэл, 2.2%-ийг машин тоног төхөөрөмж, 1.1%-ийг тавилга, эд хогшил, 0.7%-ийг номын фонд, 10.5 хувийг биет бус болон бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд 1,387,124.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 1,346.0 мянга, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,385,229.4 мянга, өмнөх оны хөрөнгийн залруулга 549.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгө данснаас хасагдаагүй бөгөөд 4,270,605.9 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2017 онд хуримтлагдсан элэгдэл нийт 3,005,583.7 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 275,870.94 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 3,281,454.6 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

## 9.2. “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой тус тайланд нэгтгэгддэг байгууллагуудын аудитаар нийт **52,259.3 мянган** төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс аудитын явцад **17,728.6** мянган төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **34,530.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал арилгах зөвлөмж өгсөн байна.

Дээрх зөрчил дутагдал нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал нь ОНХС-гаас хийгдсэн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй, дутуу бүртгэх, хуримтлагдсан элэгдлийн зардлыг дутуу тайлагнах, шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, ашиглагдаж байгаа хөрөнгийн ихэнх хувь нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой байна.

Эдгээр нь АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2 дахь заалтуудыг зөрчиж байна.

### Арав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

#### 10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар:

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 23,545.4 мянган төгрөг байснаас тайланд онд 66.0% буюу 15,456.2 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 8,089.2 мянган төгрөг болсон байна.

Нийт өр төлбөрийн 17.4% буюу 1,406.7 мянган төгрөгийн өр төлбөр нь 61-90 хоногтой, 82.6% буюу 6,682.5 мянган төгрөгийн өр төлбөр нь 91-ээс дээш хоногтой байна.

Өр, төлбөрийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Ажиллагсадтай холбоотой өглөг	33.23	1,406.66	1,373.42	4132%
Байгууллагад өгөх өглөг	8,892.29	6,682.50	(2,209.79)	-25%
Хүмүүст өгөх өглөг	14,619.85		(14,619.85)	-100%
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>23,545.37</b>	<b>8,089.16</b>	<b>-15,456.21</b>	<b>-66%</b>

Хүснэгтээс харахад: Байгууллагад болон хувь хүмүүст өгөх өглөг 2,209.8-14,619.8 мянган төгрөгөөр буурсан бол ажиллагсадтай холбоотой өглөг 1,373.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.


Нийт өглөгийн эцсийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр харуулбал:

/мянган төгрөг/

№	Байгууллагуудын төрөл	Эцсийн үлдэгдэл	Нийт дүнд эзлэх хувь
1	Төсөвт байгууллагууд	1,406.66	17.4
2	Төсөл сан	6,682.50	82.6
<b>Дүн</b>		<b>8,089.16</b>	

Хүснэгтээс харахад: Нийт өглөгийн 17.4%-ийг төсөвт байгууллагууд, 82.6%-ийг төсөл сан буюу барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна.

Сумын нийт өр төлбөрт эзэлж байгаа хувь хэмжээг диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: нийт өр төлбөрийн 17.4%-ийг төсөвт байгууллагууд, 82.6%-ийг төсөл сан буюу барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна

Өмнөх онд нийт өр төлбөрийн дийлэнх хувийг төсөвт байгууллагуудын өр төлбөр эзэлж байсан бол тайлант онд төсөл сангийн өр төлбөр 82.6%-ийг эзэлж байна. Төсөл сангийн өр төлбөр нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын барьцаа хөрөнгийн өглөг байна.

## **10.2 Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **1,406.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг аудитын явцад бүрэн залруулав.

Дээрх зөрчил дутагдал нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Өр, төлбөртэй холбоотой гарч байгаа зөрчил дутагдал нь ажиллагсдын цалингаас суутгах ХХОАТ-ыг суутган тооцоогүй, суутган тооцсон өглөгийг данс бүртгэлд тусгаагүй зэрэг нягтлан бодогчийн ажлын хариуцлагатай холбоотой байна.

Эдгээр нь НББ-ийн тухай 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4 дэх заалт, АОУС “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга”, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

### Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

#### 11.1. “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн талаар:

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд нийт 3,874,328.8 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүртгэсэн байна. Энэ нь өмнөх оноос 1,307,954.2 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын өсөлтөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн өсөлт нөлөөлсөн байна.

Үр дүнгийн тайлангаарх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	
			Дүн	Хувь
Татварын орлого	61 959,30	62 450,93	491,63	0,008
Татварын бус орлого	60 952,26	1 413 984,18	1 353 031,92	22,198
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1 000,00	1 000,00	-	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59 952,26	1 411 403,81	1 351 451,55	22,542
Бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого		1 580,38	1 580,38	
Тусгай зориулалтын шилжүүлэг	1 467 831,20	1 579 369,60	111 538,40	0,076
ОНХС-гийн шилжүүлсэн орлого	359 933,98	171 271,00	- 188 662,98	-0,524
Санхүүгийн дэмжлэг	276 625,31	289 131,22	12 505,91	0,045
Орон нутгийн санхүүжилтийн орлого	321 537,60	339 275,30	17 737,70	0,055
Нэмэлт санхүүжилтийн орлого	17 535,02	18 846,60	1 311,58	0,075
<b>Нийт дүн</b>	<b>2 566 374,66</b>	<b>3 874 328,83</b>	<b>1 307 954,17</b>	<b>0,510</b>

Хүснэгтээс харахад: Орлогын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад санхүүгийн дэмжлэг, нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, тусгай зориулалтын шилжүүлэг, татварын болон татварын бус орлого, зээлийн хүүгийн орлогууд тус тус нэмэгдэж, ОНХС-ийн шилжүүлгийн орлого буурсан байна.

#### 11.2. Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар:

2017 онд “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн хэмжээнд нийт 2,158,383.3 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөж, батлуулснаас 2,107,462.7 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, нийт орлого, санхүүжилтийн төлөвлөгөө 50,920.7 мянган төгрөгөөр тасарсан нь төсөл, сангуудын орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.



Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Шивээговь сумын 2017 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Орон нутгийн байгууллагын санхүүжилт	338 861,50	339 275,30	413,80	0,001
Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	171 271,00	171 271,00	-	-
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	1 605 399,90	1 579 369,60	- 26 030,30	- 0,016
Тусгай сангууд	41 851,00	16 546,78	- 25 304,22	- 0,605
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1 000,00	1 000,00	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2 158 383,40</b>	<b>2 107 462,68</b>	<b>- 50 920,72</b>	<b>- 0,024</b>

Хүснэгтээс харахад: тус сумын орлогын төлөвлөгөө 2.4%-иар тасарсан бөгөөд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байсан, мөн тусгай зориулалтын шилжүүлгийн хувийн цэцэрлэгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 1,605,399.9 мянга, ОНХС-гийн санхүүжилт 156,561.7 мянга, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 280,073.8 мянга, нийт 2,042,035.4 мянган төгрөгийн улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг хийхээр төлөвлөсөн боловч 98.7% буюу 2,016,005.1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Өмнөх оны тэнцлийн ашиг 14,709.2 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 31,195.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд нийт 2,479,471.8 мянган төгрөгийн орлого бүртгэж, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 2,314,193.2 мянга, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр 142,264.9 мянга, нийт 2,456,458.1 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 54,209.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний нийт орлого 2,479,471.8 мянган төгрөгөөр тайлагнасан бөгөөд төсөвт байгууллагуудын орлого, санхүүжилт 2,412,486.8 мянга, татварын бус орлого 4,534.0 мянга, татварын орлогын 62,450.9 мянган төгрөгөөс бүрдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн орлого нь орон нутгийн төсвөөс 353,570.7 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 1,579,369.6 мянга, ОНХС-гийн санхүүжилт 156,561.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,000.0 мянга, туслах үйл ажиллагааны орлого 1,953.6 мянган төгрөгөөс тус тус бүрдсэн байна.

Нэмэлт дансаар сумын ИТХ 2,110.0 мянга, ЗДТГ 5,010.0 мянга, 3 дугаар сургууль 7,320.0 мянга, 3 дугаар цэцэрлэг 3,198.5 мянга, Эрүүл мэндийн төв 1,208.1 мянга, нийт 18,846.6 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.



2017 онд сумын татварын орлогыг 56,450.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 64,031.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 13.4% буюу 7,581.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

ТТАМНАТ болон хадгаламжийн хүүгийн орлогын татварын орлогыг төлөвлөөгүй боловч холбогдох хууль тогтоомж өөрчлөгдсөнөөс шалтгаалан төлөвлөгдөөгүй орлого орсон байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг татварын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулбал:

Татварын орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
			Дүн	Хувь
<b>ХХОАТ</b>	35 000,00	41 875,70	6 875,70	19,6
<b>Үйл ажиллагааны орлого</b>	5 100,00	7 098,94	1 998,94	39,2
<b>Бууны албан татвар</b>	850,00	990,00	140,00	16,5
<b>Улсын тэмдэгтийн хураамж</b>	2 500,00	1 353,55	- 1 146,45	- 45,9
<b>Хогны төлбөр</b>	13 000,00	10 941,50	- 2 058,50	- 15,8
<b>ТТАМНАТ</b>		191,25	191,25	
<b>Хадгаламжийн хүүгийн орлого</b>		1 580,38	1 580,38	
<b>Нийт дүн</b>	<b>56 450,00</b>	<b>64 031,31</b>	<b>7 581,31</b>	<b>13,4</b>

Хүснэгтээс харахад: Тайлант онд татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 10.6%-иар давж биелсэн боловч улсын тэмдэгтийн хураамж болон хогны төлбөрийн орлого 15.8-45.9% буюу 1,146.4-2,058.5 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь тус сумын ЗДТГ-ын дарга түр томилогдсоноос шалтгаалан нотариатын үйлчилгээ явуулаагүйгээс улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Хогны орлогын төлөвлөгөө нь татварын байцаагчгүй, мөн байгаль орчны байцаагч эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацааны чөлөөтэй байснаас шалтгаалсан байна.

### 11.3. Бусад эх үүсвэрийн талаар:

Орон нутгийн орлогоос гадна төсөвт зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орлогын бусад эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

Орлогын эх үүсвэрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
			Дүн	Хувь
<b>Санхүүгийн дэмжлэг</b>	280 073,80	280 073,80	-	
<b>Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт</b>	156 651,70	156 651,70	-	
<b>Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт</b>	1 605 399,90	1 579 369,60	- 26 030,30	- 0,02
<b>Тэнцлийн ашиг</b>	17 047,00	17 047,00	-	-
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	1 000,00	1 000,00	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2 060 172,40</b>	<b>2 034 142,10</b>	<b>- 26 030,30</b>	<b>- 0,01</b>

Хүснэгтээс харахад: тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс бусад эх үүсвэрүүд бүх нэр төрлөөрөө төлөвлөгөөний дагуу бүрэн санхүүжигдсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн төлөвлөгөө 26,030.0 мянган төгрөгөөр дутуу байгаа нь хувийн цэцэрлэгийн санхүүжилтийг төлөвлөгөөнд тусгуулсан боловч тус суманд санхүүжилтийг олголтгүй Сүмбэр сумаар дамжуулан олгосонтой холбоотой байна.

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүний бүртгэл тайлагналтай холбоотой нийт **61,898.3** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **6,945.1** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **54,953.2** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 4.5% буюу **2,783.2** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 95.5% буюу **59,115.1** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцсон 1,580.4 мянган төгрөгийн татварын орлогыг хүүгийн орлогоор буюу татварын бус орлогоор тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн:** Аудитын явцад залруулав.

- Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан түрээсийн орлогын 824.4 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагаар бүртгэсэн, нэмэлт санхүүжилтийн 1,208.1 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4 дэх заалтыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн:** Аудитын явцад залруулав.

- Сумын санхүүгийн албаны дотоод хяналт сул байснаас Шивээговь сумын ИТХ-ын төсвийг үндэслэлгүйгээр 413.8 мянган төгрөгөөр нэмж олгон, батлагдсан төсвөөс илүү зарцуулсан, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс Бүжинхэн цэцэрлэгийн санхүүжилтийн 26,030.0 мянган төгрөгийн санхүүжилтийн дүнд оруулан олгохоор төлөвлөсөн боловч уг санхүүжилт тус сумын дансаар олгогдоогүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр

зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Санхүүгийн албаны зүгээс хяналт тавьж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх тухай зөвлөмж өгөх

- 2017 онд сумын татварын орлогын төлөвлөгөөнөөс улсын тэмдэгтийн хураамж 45.9% буюу 1,146.4 мянга, хогны төлбөрийн орлого 15.8% буюу 2,058.5 мянган төгрөгөөр тус тус дутуу биелүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дахь заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Татварын орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх тал дээр нөөц бололцоогоо дайчлан ажиллах тухай зөвлөмж өгөх.

Мөн аймгийн Засаг даргын 2017.05.15-ны 02/526 дугаартай албан бичгээр сумын Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сангуудыг төсвийн тодотгол хийхдээ татан буулгаж холбогдох арга хэмжээг авч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад орлогын бүрдүүлэлт, бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчил дутагдал нь орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт дутуу, нэмэлт дансаар дамжсан түрээсийн орлогыг өөрийн орлогоор бүртгэх зэрэг нягтлан бодогчийн үйл ажиллагаатай холбоотой алдаа зөрчлүүд байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтыг зөрчиж байна.

## **Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал**

### **12.1. Зардлын бүтцийн талаар:**

2017 онд “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн төсвийг өмнөх оны гүйцэтгэлээс 29,961.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 2,158,383.3 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, батлуулсан боловч хувийн цэцэрлэгийн санхүүжилт 26,030.3 мянган төгрөг олгогдоогүйгээс гүйцэтгэлээр 2,068,474.8 мянган төгрөг зарцуулж, 63,878.2 мянган төгрөгийн хэмнэлттэй мэт харагдаж байгаа боловч төсөл сангийн орлогын төлөвлөгөө 50,209.0 мянган төгрөгөөр тасарсан, сум хөгжүүлэх сангаас зээл олгогдоогүй зэргээс бодит хэмнэлт гэж үзэх үндэслэлгүй байна.

Төсөв нийт дүн болон бүлгийн дүнгээрээ хэтрээгүй хэдий ч зарим нэр төрлийн зардал хэтэрсэн байна. Үүнд: үндсэн цалингийн зардал 413.6 мянга, түлш халаалтын зардал 4,519.8 мянга, бичиг хэргийн зардал 1,156.8 мянга, тавилга эд хогшил худалдан авах зардал 169.1 мянга, шуудан холбооны зардал 129.2 мянга, эм бэлдмэлийн зардал 717.1 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Хэтэрсэн зардлуудад шинжилгээ хийж үзэхэд:

- Цалингийн зардлын хэтрэлт нь Шивээговь сумын ИТХ-д Сангийн яам болон сумын төрийн сангаас зарцуулах эрх, санхүүжилт олгогдсоноос 413.8 мянган төгрөгийн төсвийг хэтрүүлэн зарцуулсан,
- Бусад зардлын хэтрэлт нь бүлэг дотроо зохицуулалт хийгдсэнтэй тус тус холбоотой байна.

**12.2 “Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар:**

“Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **55,016.1** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **42,931.8** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **9,143.8** мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, **2,940.5** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Дээрх зөрчил дутагдал нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

